

**АРХАНГАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ
8 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны мэдээлэл

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит гуравдугаар хуралдаан 2021 оны 8-р сарын 17-ны өдөр, төлөөлөгчдийн 97.4 хувийн ирцтэйгээр хуралдав.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит гуравдугаар хуралдаанаар Аймгийн Засаг даргыг нэр дэвшүүлэх тухай, аймгийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийг батлуулах тухай, аймгийн 2021 оны төсвийн тодотгол батлах тухай, Орон нутгийн тусгай хамгаалалтад авах газрын тухай асуудлыг хэлэлцсэн бөгөөд аймгийн 2021 оны төсвийн тодотгол батлах тухай асуудлыг аймгийн Ардчилсан намын бүлгийн саналын дагуу хойшлуулсан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл

Архангай аймагт 8-р сарын 31-ны өдрийн байдлаар сүүлийн 24 цагт PCR-аар шинжилгээ хийсэн 258 сорьцноос 87, түргэвчилсэн оношлуурын 153 шинжилгээнээс 18 нийт 105 тохиолдол шинээр батлагдлаа. Үүнээс Батцэнгэл-1, Эрдэнэмандал-2, Ихтамир-3, Өлзийт-1, Өгийнуур-1, Хангай-1, Хашаат-1, Өндөр-Улаан-3, Эрдэнэбулган - 76, Булган-1 тохиолдол тус тус нэмэгдэж коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын батлагдсан нийт 3976 тохиолдолтой боллоо. Үүнд: 2020 онд Батцэнгэл – 3, 2021 онд Эрдэнэбулган – 2121, Хайрхан – 111, Эрдэнэмандал – 98, Чулуут – 91, Ихтамир – 166, Цэнхэр – 169, Хотонт – 135, Тариат – 153, Өлзийт – 162, Жаргалант - 91, Өгийнуур – 75, Хашаат – 154, Батцэнгэл – 68, Өндөр-Улаан – 99, Төвшрүүлэх – 77, Хангай - 60

Цахир – 40, Хоршоолол – 18, Цэцэрлэг – 39, Булган - 46 байна.

ӨЭМТ-үүдийн хяналтад гэрээр эмчлэгдэж байгаа 291 байна. Батлагдсан тохиолдлын ойрын хавьтлын гэрийн тусгаарлалтад – 1718 хүн байна. Аймгийн хэмжээнд 08.29-ний 00:00 цагийн байдлаар I тунд 59602, II тунд 54404 хүнийг дархлаажуулсан байна.

Аймгийн хэмжээнд дэлгэсэн тусгай эмнэлэг 23, дэлгэсэн ор 660, коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын халдварын улмаас нийт эмчлүүлж байгаа хүн 291, эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй эмчлүүлэгч 217, ӨЭМТ-ийн хяналтанд гэрээр эмчлэгдэж байгаа хүн 74, эмчлэгдэн гарсан хүний 2182 (88.1хувь) байна.

Эрдэнэбулган суманд өвчлөл нэмэгдэж орны тоо хүрэлцэхгүй байгаатай холбоотой Сувд сувилалд 60 ор дэлгэхээр шийдвэрлэн, орны тоог баталж өгөх хүсэлтийг ЭМЯ-нд уламжилсан. Мөн түүнчлэн МСҮТ-ийн байранд 40, БК-ийн байранд 250 ор дэлгэхээр төлөвлөн, үнэлгээ хийгдэж байна.

Аймаг, орон нутгийн хэмжээнд коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын халдвараар өвчилсөн иргэдийг аймгийн Нэгдсэн эмнэлгийн 120 ортой тусгайлсан эмнэлэгт тусгаарлан эмчилгээ хийж байна. Халдвар авсан иргэдийн ойрын болон дам хавьтлуудыг тандалт судалгаа хийж илрүүлэн PCR шинжилгээ авч, гэрээр тусгаарлан, биеийн байдал тогтворгүй, шинж тэмдэг нь сэжигтэй тусгаарлах зайлшгүй шаардлагатай иргэдийг тусгаарлан ажиглах байранд 7-14 хоног байрлуулж 2-3 удаагийн давтан шинжилгээ авч шинжилгээний хариуг үндэслэн хариу арга хэмжээг авч ажиллаж байна.

2021 оны 7 дугаар сард коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой

комиссын даргын тушаал, хурлын тэмдэглэл, албан даалгавар, аймгийн Онцгой комиссын хурлын тэмдэглэл, аймгийн Засаг даргын захирамжаар “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-ээс “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжин аймаг, орон нутгийн хэмжээнд хөдөлгөөний хязгаарлалт хийж, зарим байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хязгаарлалт хийн аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар хяналт тавьж, бусад төрийн байгууллагуудын ажилтан, албан хаагч нартай хамтран аймгийн Шуурхай штаб, хяналтын постонд 24 цагийн үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд мөрдүүлэх, хүн хоорондын зай бариулах, амны хаалт тогтмол зүүлгэх, ариутгал, халдваргүйжүүлэлт, агаар сэлгэлт тогтмол хийлгэх, халуун хэмжих, QR код уншуулж бүртгүүлэх талаар Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүрүүд, худалдааны төвүүд болон төрийн байгууллагуудын нийт 5000 гаруй ажилтан, албан хаагч, иргэдэд заавар, зөвлөмжийг өгч, аж ахуйн нэгжийн ариутгал, халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээ үйлчилгээнд хяналт тавьж, иргэд олон нийтийг амны хаалт зүүхийг уриалж ажилласан.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг аймгийн хэмжээний орон сууц, зах худалдааны төв, гудамж хорооллын оршин суугч, иргэдэд 190 удаа автомашинаар болон аймгийн төвд байрлах чанга яригчтай дуут дохиогоор хүргэж ажилласан. Аймгийн Шуурхай штабын гишүүд сум болон Улсын Онцгой комиссын Шуурхай штабтай цахим хурал, сургалтыг 2 удаа зохион байгуулсан.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд Татвар төлөлт

2021 оны 8 дугаар сард орлогын төлөвлөгөөг хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын төсөвт 150.0 сая төгрөг, аймгийн төсөвт 662.0 сая төгрөгийг 100 хувь төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Хөрөнгө оруулалт

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 41.177.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 45 төсөл арга хэмжээ батлагдсанаас 2021 оны 9 дүгээр сарын байдлаар 6.581.178.1 мянган төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3.666.2 мянган төгрөгийн 28 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 2021 оны 9 дүгээр сарын байдлаар 483.809.2 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Авто замын сангийн хөрөнгөөр 315.0 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр тус тус батлагдсан байна.

Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагаа

Орон нутгийн өмчит 29 төсөвт байгууллагад 52.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авах, 5 төсөвт байгууллагад 27.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэх, 22 байгууллагад 364 нэр төрлийн 364.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил актлах зөвшөөрлийг тус тус олгосон.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 12 дугаар тогтоолоор хувьчлахаар шийдвэрлэсэн үл хөдлөх хөрөнгийн нийтийн дуудлага худалдааг 2021 оны 7 дугаар сарын 6-ны өдөр зохион

байгуулж, 1 барилгыг дуудлага худалдаагаар худалдаж, орон нутгийн төсөвт 2.5 сая төгрөг төвлөрүүлэхээр болсон.

2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 100.0 сая төгрөгний 1 төсөл арга хэмжээ, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 130.0 сая төгрөгний 1 төсөл арга хэмжээ, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, сумын орон нутгийн хөгжлийн сантай хамтарсан 348.2 сая төгрөгний 1 төсөл арга хэмжээ, Орон нутгийн хөгжлийн сангийн 769.0 сая төгрөгний 7 төсөл арга хэмжээ, Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжих 30.0 сая төгрөгний өртөг бүхий 1 төсөл арга хэмжээ, Захиалгат ажил 1.337.0 сая төгрөгний 2 төсөл арга хэмжээний худалдан авалтыг тус тус зохион байгуулан, тендер зарлаж, цахим системд байршуулсан.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 1.600.0 сая төгрөгний өртөг бүхий Эрдэнэбулган сумын 2-р цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн ажил, Өндөр-Улаан, Чулуут сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 160.0 сая төгрөгний зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг хүргүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 901.2 сая төгрөгний өртөг бүхий 5 төсөл арга хэмжээний ажлын тендерт нэг ч аж ахуйн нэгж тендер ирүүлээгүй тул дахин зарласан. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих Өгийнуур сумын Орхон голын модон гүүр барих ажлын тендерийг 2 удаа зарласан боловч нэг ч аж ахуйн нэгж тендер ирүүлээгүй тул хуулийн дагуу захиалагчид зөвлөмжийг хүргүүлсэн.

Санхүүгийн хяналт

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа байгууллагуудын 2020 оны жилийн эцсийн байдлаархи шилэн дансны хуулийн хэрэгжилтийн байдалд аудит хийж, дүн мэдээг нэгтгэн Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт тус тус хүргүүлсэн. Иргэд, байгууллагаас ирүүлсэн 4 өргөдөл хүсэлтийг хүлээн авч шалган шийдвэрлэж, хариуг холбогдох байгууллага, эзэнд нь өгч ажиллалаа.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Хууль, хяналт

2021 оны 8 дугаар сард гамшиг, аюулт үзэгдэл, ослын дуудлага нийт 4 удаа гарснаас, объектын гал түймрийн зөрчил 1, гол, нуурын усанд унаж осолдсон 1, үерийн дуудлага 1, эрэн хайх, аврах ажиллагааны дуудлага 1 удаа тус тус гарсан байна.

Цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх анхааруулах 3 мэдээг ОБЕГ-ын ГШУГ-аас хүлээн авч орон нутгийн УЦУАлбанаас тодотгож 19 сумын Засаг дарга, Тамгын газрын дарга, цаг уурчид нийт 6540 алба хаагчдад багц мессежээр болон Хаан банкны онлайн сүлжээгээр дамжуулж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах үүрэг чиглэл өгч, орон нутгийн “АВ”, “Тамир” телевизээр сэрэмжлүүлгийг урсдаг зар хэлбэрээр өдөрт 6 удаа, 8 удаагийн давтамжтай нийт 288 удаа иргэдэд нэвтрүүлж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллаа.

Монгол Улсын Шадар сайдын баталсан удирдамжийн дагуу аймгийн нутаг дэвсгэрт байршилтай их, дээд болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2021 оны 8 дугаар сарын 10-ны өдрөөс 25-ны өдрийн дотор тус тус зохион байгууллаа.

“Зуны усны дадлага, сургалт зохион байгуулах тухай” Онцгой байдлын газрын даргын 2021 оны А/28 дугаар тушаалаар 8 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд Эрэн хайх, аврах салбарын 21 алба хаагч Өгийнуур сумын Орхон багийн “Өгий” нууранд гүний усны эрэн хайх аврах ажиллагаа, мандлын сэлэлт сэдвээр 4 хоногийн сургалтыг Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүн болон Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн алба хаагчидтай хамтарсан дадлага сургуулилт хийсэн.

Мөн Өгийнуурын эрэг дагуу амарч, зугаалж байгаа ард иргэдэд бага насны хүүхдийг хараа хяналтгүй нуурын ус руу явуулахгүй байх, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гол, нуурын усанд орохгүй байх, үер усны ослоос урьдчилан сэргийлэх талаар 500 ширхэг анхааруулга, санамж боршурыг тарааж урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулан ажилласан байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, цаг үеийн мэдээ мэдээлэл, заавар зөвлөмж, орон нутгийн хэмжээнд бороо, ус их байгаатай холбогдуулан үер усны ослоос урьдчилан сэргийлэх, цаг үеийн мэдээг өдөрт 2-4 удаагийн давтамжтайгаар олон нийтэд мэдээлж Онцгой байдлын газрын пэйж хуудсанд дээрх мэдээ сурвалжлагыг байрлуулж 8545 иргэнд хүрч хандалт авсан байна.

2021 оны 8-р сард аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 242 гэмт хэрэг бүртгэгдсэнээс хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 81, хулгайлах гэмт хэрэг 70, иргэдийн өмчийн хулгайн гэмт хэрэг 18, малын хулгайн гэмт хэрэг 33, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 12, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 68, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 25, гэмт хэргийн илрүүлэлт 37.6 хувьтай байна.

Нийт 13532 захиргааны зөрчил бүртгэгдсэнээс Зөрчлийн тухай хуулийн дагуу 12941 иргэнд 492234.4 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ 614.5 сая төгрөг, нөхөн төлүүлэлт 54.1 хувьтай байна.

Цэнхэр сумын Орхон багт шүүхийн шийдвэрээр ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл нь сэргэсэн “Батдөлгөөн Мөрөн” ХХК, “БМНС” ХХК, “Сэншивэе Монгол” ХХК болон хайгуулын зөвшөөрөл бүхий “Эрдэнэсийн хотхон” ХХК үйл ажиллагаа явагдаж байна. 2021 оны 8 дугаар сарын 17-ны байдлаар “Батдөлгөөн Мөрөн” ХХК нь 1 экскаватор, 1 ковш, 2 хово зэрэг техник хэрэгслийг өөрийн тусгай зөвшөөрлийн талбайд оруулан ус цэвэршүүлэх 3 даланг сэргээн засварлах, эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг эхлүүлээд байна. “БМНС ХХК” нь Өлзийт тээл гэх газарт 4 экскаватор, 2 утгуурт ачигч /ковш /, 12 автосамосвал зэрэг техник хэрэгсэл, 60 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ашиглалтын блокуудыг бэлтгэн, үйлдвэрийн хэсэгт туршилтын угаалга хийж байна.

Мөн 3 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил, өмнө жил техникийн нөхөн сэргээлт хийсэн 4 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгээд байна. Тус аж ахуй нэгжийн уул уурхайн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бичиг баримтын бүрдэлд хяналт шалгалтын ажил гүйцэтгэхэд зөрчил илрээгүй.

“Сэншивэе Монгол” ХХК нь 2 экскаватор, 2 ковш, 8 дам, 1 алт угаах төхөөрөмж зэрэг техник хэрэгсэлтэйгээр тусгай зөвшөөрөл бүхий талбайд нэвтрэхээр ирсэнийг Орхоны хяналтын пост зогсоож Өлийн давааны ард техник хэрэгслийг паркаад байна. Дээрх аж ахуй нэгжид холбогдох бичиг баримтыг мэргэжлийн байгууллагуудад шалгуулж дууссаны дараагаар техник хэрэгслийг нэвтрүүлэх чиглэл өгсөн.

“Эрдэнэсийн хотхон” ХХК нь өөрийн эзэмшлийн хайгуулын талбайд Ашигт малтмал газрын тосны газраар батлуулсан хайгуулын ажлын төлөвлөгөө Цэнхэр сумын Засаг даргаар батлуулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд хайгуулын ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд цахилгаан хайгуулыг гүйцэтгэж байна.

Стандарт, хэмжил зүйн хэлтэс 8-р сард "Дэлхийн банкны санхүүжилт"-ээр хэрэгжиж байгаа "Эрчим хүч -2" төслийн хүрээнд “ЭБЦТС” ТӨХК Архангай аймаг дахь салбартай хамтран Эрдэнэбулган сумын 6000 гаруй айл өрхөд 1 фазын ухаалаг тоолуурыг суурилуулах, анхдагч баталгаажуулалтын ажлыг 2021 оны 8 дугаар сарын 02-ны өдрөөс 27-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Боловсрол

2021 оны элсэлтийн ерөнхий шалгалтыг 2021 оны 8 дугаар сарын 19-нөөс 21-ний өдрүүдэд Эрдэнэбулган сумын 1, 2 дугаар сургууль дээр зохион байгуулж, аймгийн хэмжээнд нийт 1120 шалгуулагч 10 хичээлээр 3073 шалгалт өгөхөөс 2827 шалгалт өгч 91.9 хувийн ирцтэй байлаа.

Эрүүл мэнд

Эрүүл мэндийн байгууллагуудын дэлгэсэн оронд үнэлгээ хийхэд хичээл, сургууль эхлэхтэй холбоотой сургууль, цэцэрлэгүүдэд дэлгэсэн орны тоо цөөрч, орны тоо бууран 630 орноос 486 болж орны тоо 23 хувиар буурсан үзүүлэлттэй байсан. Үүнд дүгнэлт хийн аймаг сумын онцгой комисс эрүүл мэндийн байгууллагуудад орны тоог нэмэгдүүлэх чиглэл зааварчилгааг өгч ажилласан.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 500 сая төгрөгийн өртөг бүхий хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэрийн хангалт хийгдсэн.

Эрүүл мэндийн байгууллагуудын хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийн судалгаанд үнэлгээ хийн, цаашид шаардлагатай хэрэгцээний тооцооллыг гаргасан бөгөөд тооцооллоор нарийн шүүлтүүртэй маск 20961, комбинзон 26794, нэг удаагийн халад 46901, нэг удаагийн бээлий /хос/ 267938, нэг удаагийн улавч 97275, нэг удаагийн малгай 110153, нэг удаагийн амны хаалт 12732, нүүрний хаалт 3548, вакумтейнер 69467, уян бамбар 47147, түргэвчилсэн оношлуур 6259 шаардлагатай байна.

Үнэлгээнд тулгуурлан эрүүл мэндийн байгууллагуудад нөөцийн хангалтыг нэмэгдүүлэхийг үүрэг болгосноос гадна аймгийн Онцгой комисст эхний ээлжинд нэн шаардлагатай хамгаалах хувцас, хэрэгслийн нөөц бүрдүүлэхэд шаардлагатай тооцоо судалгааг гарган 377 сая төгрөгний хамгаалах хувцас хэрэгсэл, оношлуур, дагалдах хэрэгслийн хангалт хийлгэх хүсэлтийг хүргүүлсэн.

Товлолт дархлаажуулалт тасралтгүй зохион байгуулагдаж байна. Аймгийн вакцины нөөцийг татан авсан. Тархвар судлалын заалтаар тарваган тахлын эсрэг дархлаажуулалтанд 1862 хүнийг хамруулсан. Томуугийн эсрэг дархлаажуулалтыг зохион байгуулах бэлтгэл ажил бүрэн хангагдсан. Коронавируст халдварын эсрэг вакцинаар 12-17 насны нийт хүүхдүүдийн 79%-ийг 1-р тунд, 51%-ийг 2-р тунд хамруулаад байна. 18-аас дээш насны нийт хүн амын 86%-ийг 1-р тунд, 79%-ийг 2-р тунд хамруулаад байна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

2021 оны 8 дугаар сарын байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан LMIS программд ажил идэвхтэй хайгч 541 иргэн бүртгэлтэй байгаагаас, 527 эмэгтэй байна.

Шинэ ажлын байр 583, үүнээс байнгын ажлын байр 310, улирлын ажлын байр 120, түр ажлын байр 153 байна. Ажил олгогч байгууллагуудаас ирүүлсэн ажлын байрны захиалга 246, зуучлал 234 байна. 2021 оны 8 дугаар сарын 20-ны байдлаар 221 иргэн шинээр бүртгүүлж, LMIS программд шивж оруулсан.

Ажил идэвхитэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр нь ангилбал, боловсролгүй 7, бага 24, суурь 145, бүрэн дунд 285, техникийн болон мэргэжлийн анхан шатны 10, тусгай мэргэжлийн дунд 18, дипломын, бакалаврын 52 иргэнийг тус тус бүртгэж, мэдээллийн бааз үүсгэн ажилласан.

Нийгмийн даатгалын санд 2021 онд 11.5 тэрбум төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 тэрбум төгрөгөөр өссөн.

2021 оны 1 дүгээр сарын 01-нээс эхлэн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг ажил олгогч, даатгуулагч бүр 1 функтээр нэмэгдүүлэн, шимтгэлээ тооцож төлж байсан бол 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 1 функтээр буурсныг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийг хэрэгжилтийг зохион байгуулан ажил олгогч, түүнд ажиллагсад 469.5 сая төгрөгийн, сайн дурын даатгуулагчдад 341.8 сая төгрөгийн чөлөөлөлтийг бүртгэсэн байна.

2021 оны 8 сарын байдлаар нийт 16447 тэтгэвэр, тэтгэмж авагчдад 44,3 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн хуулийн хугацаанд шуурхай олгож ажилласан байна.

Гэр бүл, хүүхэд, залуучууд

Хүүхдийн эрхийг зөрчсөн 2 иргэнд зөрчлийн хэрэг нээж Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 1.4 дэх хэсгийн дагуу торгууль ноогдуулсан.

Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс болон осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хүмүүжүүллийн эерэг арга, хүүхэд хүмүүжүүлэх ардын ухаан, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхдийн хөгжил оролцоог дэмжих, нас сэтгэл зүйн онцлогт тохируулах хүүхэдтэй харилцах арга зүй, ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хүүхдээ хамгаалах зэрэг ерөнхий сэдвүүдийн хүрээнд 25 постер зөвлөмж, 1 подкастын 1 дугаарыг бэлтгэн олон нийтэд хүргэсэн.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд

Мал аж ахуй

“Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн А/240 дүгээр захирамжийн дагуу аймгийн хэмжээнд 3693.0 мян толгой мал угаалганд хамруулахаас 8 дугаар сарын 25-ны байдлаар 1002973 толгой мал угааж ажлын явц 27 хувьтай хийгдэж, угаалгын ажилд 184 хүн ажиллаж байна. Энэ жил бороо хур элбэгтэй тул мал угаалгын ажил бага зэрэг удааширалтай байгаа.

Газар тариалан

Архангай аймаг 2021 онд үр тариа 8703 га талбайд үүнээс улаан буудай 8403 га-д, арвай 100 га-д, овьёос 200 га-д, малын тэжээл 3300 га-д, тосны таримал 900 га-д, төмс 277.5 га-д, хүнсний ногоо 147 га-д, жимс жимсгэнэ 168.9 га-д нийт 13496.1 га талбайд тариалхаар төлөвлөж улаан буудай 9818 га-д, арвай 40.5 га-д, овьёос 241.9 га-д, тосны таримал 420 га-д, малын тэжээл 4080 га-д, төмс 278 га-д, хүнсний ногоо

147 га-д, жимс жимсгэнэ 82 га-д нийт 15107 га талбайд тариалалт хийж тариалалтыг 111.9 хувиар биелүүлж ажилласан.

Ургацын баланс, ургац хураалтад ажиллах хүн хүчний бэлэн байдал, техникийн засвар үйлчилгээ өвөлжилтийн бэлтгэл ажил, хадлан тэжээл бэлтгэлтэй танилцах ажлын хүрээнд Хайрхан, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Хотонт, Төвшрүүлэх, Цэнхэр сумаар явж, тариан талбайгаар орж тариаланчидтай уулзаж, зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа.

Ургацын балансаар үр тариа 10100 га-д тариалснаас 650 га улаанбуудай мөндөрт цохиулж, 9450 га талбайгаас 13,5 мянган тонн ургац хураахаар байна. Үүнээс улаанбуудай 9818 га-д тариалснаас 9168 га талбайгаас хураах бөгөөд нэгжийн ургац 13,4 цн/га болж, нийт 13 мянган тонн ургац хураан авахаар гарсан. Малын тэжээл 4732,7 га-д тариалсан бөгөөд 8600 тн, тосны ургамал 620 га-д тариалж, 300 орчим тн, төмс 280 га-д тариалж, 2600 тн, хүнсний ногоо 160 га-д тариалж, 1300 тн ургац хураан авах төлөвтэй байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Барилга, дэд бүтэц, газар

Архангай аймагт 2021 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 171 тэрбум 866.2 сая төгрөгийн өртөг бүхий 69 төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. 8-р сард дараах барилгуудад үе шатны хяналт хийсэн. Үүнд:

Булган сумын Соёлын төвийн барилгын ажил, гүйцэтгэл 80%

Жаргалант сумын Соёлын төвийн барилгын ажил, гүйцэтгэл 50%

Хашаат сумын Сургуулийн өргөтгөлийн барилгын ажил, гүйцэтгэл 60%

Чулуут сумын 320 суудалтай сургуулийн барилгын ажил, гүйцэтгэл 90%

Өндөр-Улаан сумын Хануй багийн бага сургуулийн барилгын ажил, гүйцэтгэл 70%

Булган сумын Сургуулийн барилгын засвар тохижилтын ажил, гүйцэтгэл 60%

Хашаат сумын сургуулийн 80 ортой дотуур байрны барилгын засвар, Төвшрүүлэх сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажил, гүйцэтгэл 20%

Цэнхэр сумын Цэнхэр багийн төвийн конторын барилгын ажил, гүйцэтгэл 10%

Жаргалант сумын Асайт багийн конторын барилгын ажил, гүйцэтгэл 50%

1-р сургуулийн өргөтгөлийн барилгын ажил, гүйцэтгэл 80%

300 ортой эмнэлгийн барилга угсралтын ажил, гүйцэтгэл 10%

Шинээр дараах 5 барилгын ажлын гэрээ байгуулсан. Үүнд: Эрдэнэмандал сумын Хан-Өндөр багийн төв, Хашаат сумын Номгон багийн төвийн барилгын ажил, Эрдэнэбулган сумын Хүнсний ногооны зоорийн барилгын ажил, Соёлын өвийг сэргээн засварлах /Архангай, Батцэнгэл сум Авга дугана/ ажил, Соёлын өвийг сэргээн засварлах /Архангай, Өлзийт сум Өөлд бээсийн хийд/ ажил.

Мөн Хашаат сумын сургуулийн 80 ортой дотуур байрны барилгын засварын ажлыг 8 дугаар сарын 19-ний өдөр улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан байна.

Барилгын материалын лаборатори нь давхардсан тоогоор 48 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 100 дээжинд 9 нэр төрлийн 56 үзүүлэлтээр сорилт шинжилгээ хийн 96 дээжийн үр дүнг боловсруулан хүргүүлж 4 дээжийн сорилт шинжилгээ хийгдэж байна.

2021 оны 8 дугаар сарын байдлаар Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 100010029401 тоот дансанд 2.547.800 төгрөгийг төвлөрүүлээд байна.

Хүнс, үйлдвэрлэл үйлчилгээ

Аймгийн хэмжээнд сүүлийн 7 хоногийн судалгаагаар гурил 347 тн буюу 45 хоног, гоймон 36.7 тн буюу 3 хоног, будаа 79.8 тн буюу 22 хоног, сахар 74.2 тн буюу 29 хоног, ургамлын тос 28.8 тн буюу 15 хоног, давс 29.2 тн буюу 69 хоног, ундны ус 39.4 мян.л буюу 1 хоног, хуурай сүү 4.09 тн буюу 3 хоног, төмс 21.5 тн буюу 9 хоног, хүнсний ногоо 11.8 тн буюу 1 хоног, өндөг 1.09 тн буюу 17 хоногийн нөөцтэй байна.

Эрүүл мэндээ хамгаалж эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд “Ажлын байрыг дэмжих” зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгож байна. 2021 оны 8 дугаар сарын 25-ны байдлаар ажлын байрыг дэмжих зээлийг “Хаан” банк 117 иргэн, аж ахуйн нэгжид 7,4 тэрбум төгрөг, “Төрийн” банк 46 иргэн, аж ахуйн нэгжид 9.0 тэрбум төгрөг, “Хас” банк 21 иргэн, аж ахуйн нэгжид 1.2 тэрбум төгрөг, “Голомт” банк 20 иргэн, аж ахуйн нэгжид 1,4 тэрбум төгрөгийн зээлүүдийг тус тус олгосон. Ажлын байрыг дэмжих зээлийг 353 иргэнд 11,7 тэрбум төгрөг, 64 аж ахуйн нэгжид 9,7 тэрбум төгрөг, нийт 417 иргэн, аж ахуйн нэгжид 21,4 тэрбум төгрөгийн зээл олгож 823 ажлын байрыг хадгалсан байна.

Хөдөө аж ахуйг дэмжих зээлийг олгож эхлээд байгаа бөгөөд 2021 оны 8 дугаар сарын 25-ны 1161 малчинд 14.2 тэрбум төгрөг, газар тариалангийн чиглэлээр 3 иргэн, аж ахуйн нэгжид 160.0 сая төгрөгийн зээл тус тус олгоод байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

-----oO-----